

## Япон-Монголын сургалтын эмнэлэг барьж, байгуулах төсөл

(Буцалтгүй тусламж)

### Үндэслэл

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын хүн ам улам бүр өсөн нэмэгдэж, орон нутгийн 1, 2-р шатлалын эрүүл мэндийн үйлчилгээ хоцрогдож, мөн эмч дутагдаж, техник, технологийн түвшин доогуур байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Орон нутгийн 1-р шатлалын эмнэлэгт эмч дутагдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор монголын эмч нар их сургуулиа төгсөөд 2 жил заавал хөдөө орон нутагт ажилласны дараа төгсөлтийн дараах сургалтанд хамрагддаг. Монгол улсын анагаахын салбарын улсын ганц сургууль нь клиникийн сургалтын байгууламж байхгүй тул оюутнуудын төгсөлтийн дараах сургалтыг улсын эмнэлгүүдэд хуваан хийлгэж байна. Эдгээр улсын

эмнэлгүүдэд төгсөлтийн дараах сургалт явуулах байгууламж байхгүй учраас клиникийн сургалтын агуулга, тоног төхөөрөмжийн бүрдүүлэлт зэрэг нь нэн тулгамдсан асуудал болж байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж, уг төсөл нь Монгол улсын анхны сургалтын эмнэлгийг Улаанбаатар хотод барьж, байгуулан төгсөлтийн дараах сургалтын чанарыг дээшлүүлж, тэргүүлэх зэрэглэлээр өндөр болох 3-р шатлалын эрүүл мэндийн үйлчилгээ, хотын 2-р шатлалын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах зорилготойгоор хэрэгжиж байна. Барилгын ажил 2018 оны 7 сард дуусах төлөвлөгөөтэй.

### Агуулга

- Төслийн нийт өртөг: 7 тэрбум 985 сая иен (Буцалтгүй тусламжийн хэмжээгээр дэлхийд дээгүүр орох өртөгөөр хэрэгжиж буй төсөл)
- Байгууламжийн танилцуулга: Хонгилын 1 давхар, газраас дээш 3 давхар, төмөр бетон цутгамал. Талбайн нийт хэмжээ: үндсэн байгууламж - 15730м<sup>2</sup>, зуухны байр - 775м<sup>2</sup>
- Амбулаторын тасаг (Гэмтэл, Нүд, Чих, Дотор-Мэдрэл, Эмэгтэйчүүд, Хүүхэд, Халдвар), дүрс оношлогооны тасаг, дурангийн тасаг, түргэн тусламжийн тасаг, эрчимт эмчилгээний тасаг, мэс заслын тасаг, хяналтын тасаг, эмнэлзүйн тасаг, эмийн тасаг, ариутгалын тасаг, гал тогоо, удирдлага-боловсрол (лекцийн танхим, хурлын танхим, номын сан), өвчний түүх, шарил хадгалах тасаг, ерөнхий үйлчилгээ, нийт орны тоо - 104.



Шав тавих ёслолын арга хэмжээ (2016.03.30)



Барилгын үйл явц (2016.9.24)

### Үр дүн

2-р шатлалын эмнэлгийн хүчин чадал бүхий Сургалтын эмнэлэг Улаанбаатар хотод баригдсанаар төгсөлтийн дараах сургалтын чанар сайжирч, тэргүүлэх зэрэглэлээр өндөр болох 3-р шатлалын эрүүл мэндийн үйлчилгээ болоод хотын

2-р шатлалын эрүүл мэндийн үйлчилгээ улам бүр сайжирч, эрүүл мэндийн салбарын боловсон хүчинг бэлтгэх орчин нөхцөл үүгээр бүрдэнэ хэмээн найдаж байна.